



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/32

Улаанбаатар хот

Нийслэлийн ногоон бүсийг ой, хээрийн түймрээс
урьдчилан сэргийлэх ажилд хяналт тавих тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Улсын Онцгой комиссын 2019 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай" 01, Онцгой байдлын ерөнхий газрын 2019 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай" 02, нийслэлийн Онцгой комиссын 2019 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай" 02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн ногоон бүсийг ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд эрчимжүүлж ажиллахыг дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Нийслэлийн ногоон бүсийг ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, хяналт шалгалт явуулах удирдамжийг хоёрдугаар, эргүүл хяналт явуулах хүн хүч, техник хэрэгслийн хуваарийг гуравдугаар, хяналт тавих бүрэлдэхүүний хуваарийг дөрөвдүгээр, шаардагдах зардлын тооцоог тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Нийслэлийн ногоон бүсийг ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт явуулахад шаардагдах 1,854,360 (нэг сая найман зуун тавин дөрвөн мянга гурван зуун наян) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧУЛТЭМСҮРЭН

